

# Давид ба Голиат

-David and Goliath-



157 Page

**Тайлбарлагч** Давид гэдэг хоньчин хүү байв. Тэрээр хонин сүргээ маш сайн хариулдаг төдийгүй ятга хөгжмөөр чадварлаг хөгжимдэж Бурханыг магтдаг нэгэн байв.

**Давид** Ёхова бол миний хоньчин надад дутагдах зүйл нэг ч үгүй~~ Уянгат ятгын аялгуугаар Бурханд талархал өргөж, шинэ дуугаар Бурханыг магтая~~

**Тайлбарлагч** Давидын ятга хөгжим сайн тоглож, Бурханыг магтдаг тухай яриа хүмүүсийн дунд тархаж эхлэв. Давид магтан дуу маш сайхан дуулаад зогсохгүй, сайн залбирдаг байлаа. Давид Бурхан үргэлж өөртэй нь хамт байдаг гэдэгт итгэдэг байлаа.



158 Page

**Тайлбарлагч** Давидыг хонио хариулж байхад хоньд уруу нь араатан амьтад их дайрдаг байжээ. Маш том арслан, баавгайтай таарна гэдэг жижигхэн Давидад аймшигтай зүйл байлаа. Тэгээд Давид Бурханаас залбиран гүйжээ.

**Давид** Бурхан минь, арслан, баавгай өөр бусад араатан амьтнаас хоньдыг минь хамгаалж өгөөч.

**Тайлбарлагч** Ийнхүү Давид араатан амьтдаас хонио хамгаалахын тулд чулуу дүүгүүрдэх бэлтгэл хийж эхлэв.

**Давид** (Дүүгүүрийн чимээ)

**Тайлбарлагч** Хонин сүрэг уруу нь дайрч байгаад Давидын дүүгүүрийн чулуунд оногдсон арслан, амандаа зуусан хургыг хаяад айн зугтажээ.



159 Page

**Тайлбарлагч** Нэгэн өдөр Израиль улс, Филистчүүдтэй маш том тулааныг хийх болжээ. Аавынхаа захиасаар ах нарыгаа эргэхээр дайны талбарт ирсэн Давид, Филистийн ирүүл цэрэг Голиат Бурханы ард түмнийг доромжилж байхыг харжээ.

**Голиат** Хахаха!! Надтай тулалдаад ялах нэг ч хүн байхгүй биз дээ? Аймхайнууд аа!

**Тайлбарлагч** Давид хүмүүст яаж филистчүүд бурханы хүмүүсийг доромжилж чадаж байна гэж хэлэв. Зарим хүмүүс нь тэр үгийг сонсоод Саул хаанд дамжуулан хэлэв. Саул хаан давидийг дуудуулав.

**Давид** Хаантан минь! Тэр Филист хүнээс болж, бидний зориг мохог ёсгүй. Хааны боол би тэр аварга биетэй Голиаттай тулалдая. Бурхан надад заавал туслах болно.

**Саул** Чи яаж тэр Филист хүнтэй тулалдана гэж? Чиний нас бага байна. Харин тэр Филист бэлтгэгдсэн цэрэг шүү дээ.

**Давид** Би аавынхаа хоньдыг хариулж өссөн билээ. Арслан, баавгай хонин сүрэг уруу минь дайрах үед би тэднээс хонио хамгаалдаг байсан. Харин Амьд оршигч Бурханы цэргийг доромжлогч хүнийг яаж зүгээр орхих билээ?



160 Page

**Тайлбарлагч** Давид бүх зүйл дээр Бурхан өөрт нь тусална гэдэгт итгэж байлаа. Бурханыг доромжлогч Филист цэрэгтэй тулалдахад ч гэсэн Бурханы тусламжаар дийлж чадна гэж итгэж байлаа.

---

**Тайлбарлагч** Давид аварга биетэй Голиаттай тулалдахаар явахдаа хонио хамгаалахад хэрэглэдэг саваа мод болон дүүгүүр, таван ширхэг мөлгөр чулууг авч явжээ. Давид Голиаттай тулалдааны талбарт очих үед Голиат түүнийг хараад чанга дуугаар шоолжээ.

**Голиат** Хахаха. Чи намайг нохой гэж бодон саваа мод авчрав уу? Муу тэнэг жаал

**Тайлбарлагч** Гэсэн ч Давид айхгүй байлаа. Давид чанга дуугаар Голиатад ийнхүү хэллээ.

**Давид** Чи илд, бамбай, жад барьж над уруу ирж байгаа бол, харин би чиний доромжилсон Израилийн бүх цэргийн Бурхан, түмэн цэргийн ЭЗЭНий нэрээр чам уруу ирж байна!!

---



161 Page

**Тайлбарлагч** Давид Голиат уруу гүйн очоод дүүгүүрээр дүүгүүрдэн Голиатын духыг оножээ. Филист цэрэг гэнэт ирсэн чулуунаас бултаж чадсангүй. Чулуу дунханд нь онож газарт пид хийн ухаан алдаж унажээ. Давидын гартилд байхгүй байсанд, тэр Голиатын илдийг сугалан толгойг нь тасалжээ.

Үүнийг харсан Филистчууд айцгаан, зугтаан оджээ. Тэр өдөр Израильчууд дайнд ялав. Давид хонио хариулахдаа, Бурханы тусламжинд найддаг шигээ энэ тулаанд ч гэсэн Бурханд найдах үед тэр ялж чаджээ. Хонин сүргээ хамгаалахын тулд сурсан арга нь хожим Израилийг аюулт дайснаас аврах арга болон ашиглагддээ.